



**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 1/13

Батноров сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, Спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал, Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1."Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ"-ний хүрээнд Эх үрсийн баяраар зохион байгуулагдах унадаг дугуйн уралдааны ажлын удирдамжийг 1 дүгээр, зарцуулах хөрөнгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эх үрсийн баяраар зохион байгуулагдах унадаг дугуйн уралдааны зардалд 1,337,300 /нэг сая гурван зуун гучин долоон мянга гурван зуун/ төгрөгийг зарцуулсугай.

3.Дээрх хөрөнгийг хөтөлбөрийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д.Байгалмаа)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *П.Лхагважав* П.ЛХАГВАЖАВ





**ЭХ ҮРСИЙН БАЯРААР ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ УНАДАГ
ДУГУЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

Зохион байгуулагч байгууллага: Батноров сумын Эрүүл мэндийн төв

Зохион байгуулах огноо: 2025 оны 6 дугаар сарын 1

Зохион байгуулах газар: ЭМТөвийн баруун тоглоомын талбайд

Уралдааны зорилго:

- Хүүхдүүдийн бие бялдрыг хөгжүүлэх
- Эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх
- Хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх
- Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх

Оролцогчид

- Ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн сурагчид
- Хувийн унадаг дугуй, хамгаалалтын малгайтай байх
- Уралдаанд оролцохыг зөвшөөрсөн эцэг эхийн бичгээр өгсөн зөвшөөрөлтэй байх

Уралдааны ангилал

- 1–2-р ангийн хүүхдүүд
- 3–4-р ангийн хүүхдүүд
- 5-6-р ангийн хүүхдүүд
(Насны ангилал тус бүрд тусдаа уралдана.)

Уралдааны зам, дүрэм

- Уралдааны зам: (ЭМТ-ийн баруун талын талбайд урт: нь 300-500 м)
- Уралдаан нь цагийн баримжаатай, шүүгчийн хяналтад явагдана.
- Хамгаалалтын малгайгүй, ослын эрсдэлтэй хүүхдийг оролцуулахгүй
- Дугуйн бүрэн бүтэн байдалд хяналт тавина.

Шагнал урамшуулал

- Тус бүрийн ангилалд I, II, III байр эзэлсэн хүүхдүүдэд , өргөмжлөл, витаминжуулалтын багц

Зохион байгуулалтын хуваарь

- 09:00 – 09:30 – Бүртгэл, дугуйны хяналт
- 09:30 – 10:00 – Нээлтийн ажиллагаа
- 10:00 – 12:00 – Уралдааны эхний болон дараагийн шат
- 12:00 – 12:30 – Шүүгчдийн дүн гаргах
- 12:30 – 13:00 – Шагнал гардуулах ажиллагаа

Холбоо барих

- Хариуцсан зохион байгуулагч: Их эмч А. Цэндсүрэн утас:99648505, их эмч Ж. Авирмэд, нийгмийн эрүүл мэндийн ажилтан О. Баярцэцэг
- Сургуулийн захиргаа, биеийн тамирын багш нар

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН НЭМЭ: *Баярцэцэг* БАЯРЦЭЦЭГ
ХЯНАСАН ЭМТ-ИЙН ДАРГА: *П. Лхагважав* П. ЛХАГВАЖАВ

Даргын 2025 оны 06 сарын 27 өдрийн
А/Б тоот тушаалын хавсралт



**“Унадаг дугуйн уралдаанд ” зарцуулагдах
витаминжуулалтын төсөв**

№	Амин дэмүүд	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Витагрипп	90	1200	108.000
2	Куркума том	9	13500	121.500
3	Витамин Д 2000	135	6000	810.000
4	Зөв аарцны үрэл	9	5700	51.300
5	Хулдаасан хэвлэл	1	54.000	54.000
6	Аньсны үрэл	275	700	192.500
Нийт үнэ				1,337,300